

СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сэлэнгэ аймгийн Цагдаагийн газрын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: СЭА-2024/23/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.selenge@audit.gov.mn	Дарга, тэргүүлэх аудитор: Ч.Энхтуяа Утас: 7036-3040 Цахим хаяг: enkhtuyach@audit.gov.mn
Сүхбаатар сум	Аудитын менежер: Б.Батмөнх Утас: 7036-3036 Цахим хаяг: batmunkhb@audit.gov.mn
2024 он	Ахлах аудитор: С.Баасансүрэн Утас: 7036-2442 Цахим хаяг: Baasansurens@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1. Аудитын дүгнэлт	3-4
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	5-12
3. Санхүүгийн тайлангийн тодруулга	12-17
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа	12
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин	12-13
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	13
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт	14
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	14-17
4. Аудитын тайлан	17-23
4.1 Ерөнхий зүйл	17-18
4.2 Материаллаг байдал	18
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	18
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	19
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	19-20
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	20
5. Аудитын илрүүлэлт	20-21
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл	21-22

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ГХУС	Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх
ЗДНХ	Засаг даргын нөөц хөрөнгө
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
НДШ	Нийгмийн даатгалын шитгэл
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
ТБОНӨХБАУХА	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ЦЕГ	Цагдаагийн ерөнхий газар



СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

II баг, Цагаан эрэг, Сүхбаатар сум,
Сэлэнгэ аймаг, 43031
Утас/Факс: (976)-7336-3049
Цахим шуудан: Selenge@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

СЭЛЭНГЭ АЙМГИЙН ЦАГДААГИЙН
ГАЗРЫН ДАРГА, ЦАГДААГИЙН
ХУРАНДАА Ж.ЭНХ-ОД ТАНАА

2024.02.20 № СЭА-2024/23/НА-СТА-ТШЗ
танай _____-ны № _____

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Сэлэнгэ аймгийн Цагдаагийн газрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Сэлэнгэ аймгийн Цагдаагийн газрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Тус Цагдаагийн газар нь ЦЕГ-ын даргын 2013 оны 06 дугаар сарын 22-ны өдрийн 422 дугаар тушаалаар баталсан Монгол Улсын цагдаа, дотоодын цэргийн байгууллагын хэмжээнд мөрдөгдөх "Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг"-ийг мөрдөж байгаа нь түүнээс хойш нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, зааварт орсон нэмэлт өөрчлөлтүүдтэй нийцэхгүй байна.

ЦЕГ-ын даргын 2023 оны 2/352, Санхүү, ар талын албаны даргын 16/2918 дугаар албан бичгүүдээр "Төсвийн зардлын үлдэгдлээр байгууллагынхаа хэрэгцээнд шаардлагатай материалыг худалдан авах болон "Ахмадын сан"-д шилжүүлж, төсвийг бүрэн зарцуулах ажлыг зохион байгуулах" гэж үүрэг, ажлын чиглэл өгсний дагуу дараах ажил гүйлгээг хийж гүйцэтгэсэн байна. Үүнд:

- Жилийн эцэст хангамж, бараа материалын зардлын төсвийн хэмнэлтийг татан төвлөрүүлэлгүйгээр 51,208.6 мянган төгрөгийн шатахуун нөөцөлсөн,

- Төсвийн зарцуулагдаагүй үлдэгдэл 73,221.9 мянган төгрөгийг Ахмадын сангийн 100130012503 дугаар дансанд төвлөрүүлсэн байна.

Аудитын гол асуудал

Тус Цагдаагийн газар нь ЦЕГ-ын даргын 2013 оны 06 дугаар сарын 22-ны өдрийн 422 дугаар тушаалаар баталсан цагдаа, дотоодын цэргийн байгууллагын хэмжээнд мөрдөгдөх “Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг”-ийг мөрдөж байгаа нь түүнээс хойш нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, зааварт орсон нэмэлт өөрчлөлтүүдтэй нийцэхгүй байна.

Бусад асуудлын хэсэг

Тус газар нь тайлант оны “Гүйцэтгэлийн төлөвлөгөө”-нд 5 зорилтын хүрээнд 35 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, 84.5 хувийн гүйцэтгэлтэй үнэлэгдсэн байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэл гаргах хэрэгслэлийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ч.ЭНХТУЯА

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/ төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	234,910,201.19	367,797,021.63
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	28,642,800.00	86,634,027.50
31200	Банкинд байгаа бэлэн мөнгө	28,642,800.00	86,634,027.50
31210	Төгрөг	28,642,800.00	86,634,027.50
31211	Төрийн сангийн харилцах	28,642,800.00	86,634,027.50
33	АВЛАГА	17,602,000.00	17,602,000.00
33300	Татаас, санхүүжилтийн авлага	17,602,000.00	17,602,000.00
35	БАРАА МАТЕРИАЛ	188,665,401.19	263,560,994.13
35100	Түүхий эд материал	102,115,918.89	114,751,818.01
35110	Тусгай зориулалттай материал	94,501,418.89	107,659,818.01
35130	Эм боох материал	7,614,500.00	7,092,000.00
35400	Хангамжийн материал	75,411,082.30	141,387,776.12
35410	Бичиг хэргийн материал	3,267,340.00	3,545,210.00
35420	Аж ахуйн материал	65,605,158.20	81,621,768.02
35440	Түлш, шатах тослох материал	4,168,492.60	51,208,631.60
35460	Хүнсний материал	7.50	7.50
35470	Бусад хангамжийн материал	2,370,084.00	5,012,159.00
35600	Мал амьтад	11,138,400.00	7,421,400.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,743,688,786.44	1,609,337,727.50
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,743,688,786.44	1,609,337,727.50
39200	Биет хөрөнгө	1,520,229,686.44	1,365,685,127.62
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,359,309,136.30	1,359,309,136.30
39202	Хуримтлагдсан элэгдэл	(269,804,730.46)	(347,494,525.66)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	240,155,766.00	239,155,766.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(137,996,993.46)	(172,808,999.62)
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	646,955,549.69	684,001,758.89
39206	Хуримтлагдсан элэгдэл	(420,108,238.59)	(486,703,412.66)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	84,598,742.23	93,977,677.23
39208	Хуримтлагдсан элэгдэл	(43,866,345.27)	(64,764,072.98)
39211	Батлан хамгаалах, цэргийн зориулалттай тоног төхөөрөмж	60,986,800.00	60,986,800.00
39214	Бусад үндсэн хөрөнгө	-	6,093,800.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-	(6,068,799.88)
39300	Биет бус хөрөнгө	223,459,100.00	243,652,599.88
39301	Программ хангамж	1,225,000.00	56,298,180.80
39302	Хуримтлагдсан элэгдэл	(1,225,000.00)	(36,104,680.92)
39303	Бусад биет бус хөрөнгө	223,459,100.00	223,459,100.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	1,978,598,987.63	1,977,134,749.13
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,978,598,987.63	1,977,134,749.13
51	Засгийн газрын хувь оролцоо	1,978,598,987.63	1,977,134,749.13
51100	Засгийн газрын оруулсан капитал	1,226,962,655.49	1,226,962,655.49
511001	Улсын төсвийн оруулсан хөрөнгө	1,226,962,655.49	1,226,962,655.49
51200	Хуримтлагдсан үр дүн	(93,350,274.60)	(94,814,513.10)
51210	Өмнөх үеийн үр дүн	20,243,690.31	(93,350,274.60)
51220	Тайлант үеийн үр дүн	(113,593,964.91)	(1,464,238.50)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	844,986,606.74	844,986,606.74
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	1,978,598,987.63	1,977,134,749.13

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/ төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	2,946,224,281.00	4,553,527,207.82
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	137,832,251.00	118,573,857.82
120	Нийтлэг татварын бус орлого	137,832,251.00	118,573,857.82
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	39,038,975.00	45,756,985.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	17,407,650.00	11,964,200.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	12,630,800.00	-
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	9,000,525.00	33,792,785.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	68,437,696.00	19,205,000.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	30,355,580.00	53,611,872.82
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,808,392,030.00	4,434,953,350.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	2,658,009,500.00	4,323,035,500.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	2,658,009,500.00	4,323,035,500.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	150,382,530.00	111,917,850.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	11,800,000.00	53,721,400.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	3,465,170.00	590,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	135,117,360.00	57,606,450.00
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	3,056,002,273.64	4,553,685,237.91
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,056,002,273.64	4,553,685,237.91
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,027,258,893.40	4,090,499,062.01
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	2,187,295,487.40	3,403,434,205.79
210101	Үндсэн цалин	1,293,438,109.02	2,234,467,943.12
210102	Нэмэгдэл	877,850,180.60	1,115,439,382.76
210103	Унаа хоолны хөнгөлөлт	16,007,197.78	26,449,020.00
210104	Урамшуулал	-	27,077,859.91
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	45,993,891.23	78,950,024.31
210201	Тэтгэврийн даатгал	6,195,544.25	427,549.00
210202	Тэтгэмжийн даатгал	254,801.00	58,042.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	203,841.00	39,650.00
210204	Ажилгүйдлийн даатгал	50,960.00	7,883.00
210205	Эрүүл мэндийн даатгал	39,288,744.98	78,416,900.31
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	88,146,158.00	83,845,551.91
210301	Гэрэл, цахилгаан	12,837,603.00	13,503,445.91
210302	Түлш, халаалт	67,690,029.00	61,076,816.00
210303	Цэвэр, бохир ус	7,618,526.00	9,265,290.00
2104	Хангамж, бараа материалын зардал	251,374,719.23	204,978,341.97
210401	Бичиг хэрэг	23,429,140.00	15,673,730.00
210402	Тээвэр, шатахуун	194,414,010.00	133,175,861.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	13,784,870.13	11,827,232.09
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	209,000.00	9,470,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	19,537,699.10	7,797,800.00
210408	Бараа материал акталсны зардал	-	27,033,718.88
2105	Нормативт зардал	26,307,800.00	20,354,397.50

210502	Хоол, хүнс	26,307,800.00	19,969,797.50
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	-	384,600.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	86,465,730.00	32,790,083.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	-	265,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	1,997,010.00	414,000.00
210604	Урсгал засвар	84,468,720.00	32,111,083.00
2107	Томилолт, зочны зардал	31,933,500.00	9,582,800.00
210702	Дотоод албан томилолт	31,933,500.00	9,582,800.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	12,874,603.00	9,915,720.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	10,181,400.00	5,389,500.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	544,631.00	-
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	-	4,000,000.00
210807	Газрын төлбөр	1,818,792.00	151,780.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	329,780.00	374,440.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	296,867,004.54	246,647,937.53
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	27,474,000.00	500,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	8,732,520.00	1,040,462.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	260,660,484.54	245,107,475.53
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	28,743,380.24	463,186,175.90
2132	Бусад урсгал шилжүүлэг	12,260,000.00	451,110,134.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	-	7,175,980.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	-	232,503,454.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	-	112,311,200.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	12,260,000.00	99,119,500.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	16,483,380.24	12,076,041.90
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	16,424,020.24	8,470,051.90
213304	Хөрөнгийн	-	3,605,990.00
213305	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	59,360.00	-
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	(109,777,992.64)	(158,030.09)
IV	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	-	26,706,400.96
145002	Үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны олз	-	26,706,400.96
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	3,815,972.27	28,012,609.37
225001	Үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны гарз	3,815,972.27	27,912,609.37
225011	Үнэ төлбөргүй гарсан зардал - Бараа материал	-	100,000.00
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	(113,593,964.91)	(1,464,238.50)

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/ төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	2,876,124,480.00	4,537,741,445.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	50,130,450.00	85,186,095.00

120	Нийтлэг татварын бус орлого	50,130,450.00	85,186,095.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	50,130,450.00	85,186,095.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	17,407,650.00	11,964,200.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	32,722,800.00	73,221,895.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,825,994,030.00	4,452,555,350.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	2,658,009,500.00	4,323,035,500.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	2,658,009,500.00	4,323,035,500.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	167,984,530.00	129,519,850.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилалдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	11,800,000.00	53,721,400.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	3,465,170.00	590,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	152,719,360.00	75,208,450.00
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,823,005,480.00	4,411,087,882.50
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,823,005,480.00	4,411,087,882.50
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,762,308,099.76	3,925,951,706.60
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	2,193,035,487.40	3,449,963,394.07
210101	Үндсэн цалин	1,297,018,109.02	2,112,261,142.66
210102	Нэмэгдэл	880,010,180.60	1,233,244,005.50
210103	Унаа хоолны хөнгөлөлт	16,007,197.78	33,770,660.00
210104	Урамшуулал	-	70,687,585.91
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	45,993,891.23	72,409,336.03
210205	Эрүүл мэндийн даатгал	45,993,891.23	72,409,336.03
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	88,146,158.00	84,745,551.91
210301	Гэрэл, цахилгаан	12,837,603.00	14,103,445.91
210302	Түлш, халаалт	67,690,029.00	61,376,816.00
210303	Цэвэр, бохир ус	7,618,526.00	9,265,290.00
2104	Хангамж, бараа материалын зардал	249,701,440.13	206,128,732.09
210401	Бичиг хэрэг	22,403,800.00	12,445,100.00
210402	Тээвэр, шатахуун	205,157,770.00	177,096,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	13,784,870.13	11,827,232.09
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	209,000.00	300,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	8,146,000.00	4,460,400.00
2105	Нормативт зардал	29,027,300.00	27,506,197.50
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	1,289,500.00	180,000.00
210502	Хоол, хүнс	26,307,800.00	25,826,197.50
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,430,000.00	1,500,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	57,427,200.00	34,923,495.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	10,366,500.00	4,855,695.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	1,055,000.00	2,000,000.00
210604	Урсгал засвар	46,005,700.00	28,067,800.00
2107	Томилолт, зочны зардал	31,933,500.00	11,691,900.00
210702	Дотоод албан томилолт	31,933,500.00	11,691,900.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	14,662,823.00	23,728,500.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	12,299,400.00	18,600,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	544,631.00	446,500.00

210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	-	232,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	-	4,000,000.00
210807	Газрын төлбөр	1,818,792.00	450,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	52,380,300.00	14,854,600.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	45,372,300.00	13,390,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	7,008,000.00	1,464,600.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	60,697,380.24	485,136,175.90
2132	Бусад урсгал шилжүүлэг	26,612,000.00	455,458,134.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	14,352,000.00	14,495,980.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	-	232,503,454.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	-	112,311,200.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	12,260,000.00	96,147,500.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	34,085,380.24	29,678,041.90
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	16,424,020.24	8,470,051.90
213305	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	17,661,360.00	21,207,990.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	53,119,000.00	126,653,562.50
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	24,476,200.00	68,662,335.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	24,476,200.00	68,662,335.00
2200	Дотоод эх үүсвэрээр	24,476,200.00	68,662,335.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	24,476,200.00	68,662,335.00
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	(24,476,200.00)	(68,662,335.00)
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	28,642,800.00	57,991,227.50
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	28,642,800.00
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	28,642,800.00	86,634,027.50

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/ төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,226,962,655.49	844,986,606.74	20,243,690.31	2,092,192,952.54
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,226,962,655.49	844,986,606.74	20,243,690.31	2,092,192,952.54
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-	-	-	-
5	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	-	-	-	-
6	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
7	Өмчид гарсан өөрчилөлт	-	-	-	-
8	Зарласан ногдол ашиг	-	-	-	-
9	Тайлант үеийн үр дүн	-	-	(113,593,964.91)	(113,593,964.91)

10	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,226,962,655.49	844,986,606.74	(93,350,274.60)	1,978,598,987.63
11	2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	1,226,962,655.49	844,986,606.74	(93,350,274.60)	1,978,598,987.63
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,226,962,655.49	844,986,606.74	(93,350,274.60)	1,978,598,987.63
14	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-	-	-	-
15	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	-	-	-	-
16	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
17	Өмчид гарсан өөрчилөлт	-	-	-	-
18	Зарласан ногдол ашиг	-	-	-	-
19	Тайлант үеийн үр дүн	-	-	(1,464,238.50)	(1,464,238.50)
20	2023 оны 12-р сарын 30-наарх үлдэгдэл	1,226,962,655.49	844,986,606.74	(94,814,513.10)	1,977,134,749.13

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/ төгрөгөөр/

Дансны код	ҮЗҮҮЛЭЛТ	ТӨЛӨВЛӨГӨӨ	ГҮЙЦЭТГЭЛ	Дүн	Хувь
21	I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	4,333,040,500.00	4,326,529,648.10	6,510,851.90	99.85
210	УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН	4,333,040,500.00	4,326,529,648.10	6,510,851.90	99.85
2101	Бараа, үйлчилгээний зардал	3,890,615,700.00	3,884,106,514.10	6,509,185.90	99.83
210101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	3,451,066,000.00	3,449,963,394.07	1,102,605.93	99.97
210102	Үндсэн цалин	2,215,264,500.00	2,112,261,142.66	103,003,357.34	95.35
210103	Нэмэгдэл	1,176,066,500.00	1,233,244,005.50	(57,177,505.50)	104.86
210104	Унаа, болон бусад нөхөн олговор	32,310,000.00	33,770,660.00	(1,460,660.00)	104.52
2102	Урамшуулал	27,425,000.00	70,687,585.91	(43,262,585.91)	257.75
210205	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	72,411,200.00	72,409,336.03	1,863.97	100.00
2103	Эрүүл мэндийн даатгал	72,411,200.00	72,409,336.03	1,863.97	100.00
210301	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	87,524,500.00	84,745,551.91	2,778,948.09	96.82
210302	Гэрэл цахилгаан	14,109,600.00	14,103,445.91	6,154.09	99.96
210303	Түлш, халаалт	64,669,400.00	61,376,816.00	3,292,584.00	94.91
2104	Цэвэр, бохир ус	8,745,500.00	9,265,290.00	(519,790.00)	105.94
210401	Хангамж, бараа материалын зардал	197,383,400.00	196,488,732.09	894,667.91	99.55
210402	Бичиг хэрэг	12,446,400.00	12,445,100.00	1,300.00	99.99
210403	Тээвэр (шатахуун)	168,319,200.00	167,456,000.00	863,200.00	99.49
210405	Шуудан холбоо, интернэтийн төлбөр	11,829,200.00	11,827,232.09	1,967.91	99.98
210406	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	303,600.00	300,000.00	3,600.00	98.81
2105	Бага үнэтэй, түргэн элэгдэх, аж ахуйн эд зүйлс	4,485,000.00	4,460,400.00	24,600.00	99.45
210501	Нормативт зардал	18,994,200.00	18,993,500.00	700.00	100.00
210502	Эм бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	180,000.00	180,000.00	-	100.00

210503	Хоол, хүнс	17,314,200.00	17,313,500.00	700.00	100.00
2106	Нормын хувцас зөөлөн эдлэл	1,500,000.00	1,500,000.00	-	100.00
210601	Эд хогшил худалдан авах	30,961,000.00	30,961,000.00	-	100.00
210603	Багаж, техник, хэрэгсэл	10,800,000.00	10,800,000.00	-	100.00
210604	Хөдөлмөр хамгааллын хэрэгсэл	2,000,000.00	2,000,000.00	-	100.00
2107	Урсгал засвар	18,161,000.00	18,161,000.00	-	100.00
210702	Томилолт, зочны зардал	7,046,900.00	5,351,900.00	1,695,000.00	75.95
2108	Дотоод албан томилолт	7,046,900.00	5,351,900.00	1,695,000.00	75.95
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр	23,728,500.00	23,728,500.00	-	100.00
210804	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	18,600,000.00	18,600,000.00	-	100.00
210805	Тээврийн хэрэгслийн татвар	446,500.00	446,500.00	-	100.00
210806	Тээврийн хэрэгслийн оношилгоо	232,000.00	232,000.00	-	100.00
210807	Мэдээллийн технологийн зардал	4,000,000.00	4,000,000.00	-	100.00
2201	Газрын төлбөр	450,000.00	450,000.00	-	100.00
210902	Бараа үйлчилгээний бусад зардал	1,500,000.00	1,464,600.00	35,400.00	97.64
	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,500,000.00	1,464,600.00	35,400.00	97.64
2132	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	442,424,800.00	442,423,134.00	1,666.00	100.00
213204	Бусад урсгал шилжүүлэг	442,424,800.00	442,423,134.00	1,666.00	100.00
213207	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	8,750,000.00	8,748,480.00	1,520.00	99.98
213208	Тэтгэвэрт гарахад нь олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	232,503,600.00	232,503,454.00	146.00	100.00
213209	Хөдөө ОН-т тогтвор суурьшилтай ажилласны тэтгэмж	112,311,200.00	112,311,200.00	-	100.00
	Нэг удаагийн тэтгэмж урамшуулал	88,860,000.00	88,860,000.00	-	100.00
1310	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	4,333,040,500.00	4,326,529,648.10	6,510,851.90	99.85
131001	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	4,323,035,500.00	4,314,565,448.10	8,470,051.90	99.80
120004	Улсын төсвөөс санхүүжих	4,323,035,500.00	4,314,565,448.10	8,470,051.90	99.80
1200041	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	10,005,000.00	11,964,200.00	(1,959,200.00)	119.58
4	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	10,005,000.00	11,964,200.00	(1,959,200.00)	119.58
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	0.00	(0.00)	-
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	0.00	(0.00)	-
61	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	-	-	-	-
62	БАЙГУУЛЛАГЫН ТОО	-	-	-	-
620001	АЖИЛЛАГСДЫН ТОО	152.00	133.00	19.00	87.50
620002	Удирдах ажилтан	1.00	1.00	-	100.00
620003	Гүйцэтгэх ажилтан	147.00	130.00	17.00	88.44
63	Үйлчлэх ажилтан	4.00	2.00	2.00	50.00

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/ төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	129,519,850.00
21	УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН	129,519,850.00
210	Бараа, үйлчилгээний зардал	108,311,860.00

2104	Хангамж, бараа материалын зардал	9,640,000.00
210402	Тээвэр (шатахуун)	9,640,000.00
2105	Нормативт зардал	6,817,030.00
210502	Хоол, хүнс	6,817,030.00
2106	Эд хогшил худалдан авах	72,624,830.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	62,718,030.00
210604	Урсгал засвар	9,906,800.00
2107	Томилолт, зочны зардал	6,340,000.00
210702	Дотоод албан томилолт	6,340,000.00
2201	Бараа үйлчилгээний бусад зардал	12,890,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	12,890,000.00
	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	21,207,990.00
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	21,207,990.00
213503	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, төвлөрүүлэх шилжүүлэг	21,207,990.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	129,519,850.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	129,519,850.00
131103	ЗГНХ, Засаг даргын нөөц хөрөнгө түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс зохих байгууллагын шийдвэрийн дагуу тухай төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	53,721,400.00
131104	Дээд шатны төсвийн захирагчаас төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	590,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	75,208,450.00
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Сэлэнгэ аймгийн Цагдаагийн газар нь *“Найдвартай, баталгаатай үйлчилгээ-иргэд олон нийтийн итгэл, дэмжлэгийг нэмэгдүүлэх”* гэсэн зорилгын хүрээнд үйл ажиллагаа явуулж байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Цагдаагийн газрын үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлж, хэрэгжүүлсэн байна. Үүнд:

- *Гэмт хэрэгтэй тэмцэх,*
- *Нийгмийн хэв журам сахиулах,*
- *Олон нийтийн аюулгүй байдлыг хангах,*
- *Захиргааны хяналт тавих үүрэг гүйцэтгэх буюу хуулиар хүлээлгэсэн хуулийн биелэлтэд хяналт тавих.*

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлтүүд орсон байна. Үүнд:

- Монгол Улсын 2023 оны Төсвийн тухай хуулиар төсөв, санхүүжилттэй холбоотой,

- Төрийн хэмнэлтийн тухай хуульд 2023 оны 06 дугаар сарын 16, 07 дугаар сарын 07-нд нэмэлт өөрчлөлт орсон,
- Төрийн албаны тухай хуульд 2023 оны 01 дүгээр сарын 06, 05 дугаар сарын 04, 06 дугаар сарын 16, 07 дугаар сарын 07, 11 дүгээр сарын 10, 12 дугаар сарын 07-нд тус тус нэмэлт өөрчлөлт орсон,
- Хөдөлмөрийн тухай хуульд 2023 оны 07 дугаар сарын 07-нд нэмэлт өөрчлөлт орсон,
- Засгийн газрын 2023 оны 06 дугаар сарын 21-ний өдрийн 241 дүгээр тогтоолоор төрийн албаны зарим албан тушаалын цалингийн сүлжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоосон гэх мэт.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна гэж үзлээ.

Тайлант онд аймгийн Цагдаагийн газрын санхүүгийн үйл ажиллагаанд ЦЕГ-ын Дотоод хяналт, шалгалт, аюулгүй байдлын газраас дотоод аудит, хяналт шалгалт хийснээс гадна сар бүрийн төсвийн гүйцэтгэлийн мэдээ, шилэн дансны мэдээллээр дамжуулан тухай бүр хяналт, шалгалтыг хэрэгжүүлсэн байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэх ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Аймгийн Цагдаагийн газар нь 2023 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

ЦЕГ-ын даргын 2013 оны 06 дугаар сарын 22-ны өдрийн 422 дугаар тушаалаар Монгол Улсын цагдаа, дотоодын цэргийн байгууллагын хэмжээнд мөрдөгдөх Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталсан байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт тусгагдсан зарим хууль тогтоомж, эрх зүйн актуудад өөрчлөлт орсон байна. Иймд Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2 дахь *“Аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага нь нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, зааварт нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталж, мөрдөж ажиллана”* гэсэн заалтын дагуу нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, зааварт нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталж, мөрдөж ажиллах нь зүйтэй юм.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Аймгийн Цагдаагийн газрын 2023 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 1,464.3 мянган төгрөгөөр буюу 0.07 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/мянган төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	28,642.8	86,634.1	57,991.3
Авлага	17,602.0	17,602.0	-
Бараа материал	188,665.4	263,560.9	74,895.5
Үндсэн хөрөнгө	1,743,688.8	1,609,337.7	(134,351.1)
Нийт хөрөнгө	1,978,599.0	1,977,134.7	(1,464.3)
Өр төлбөр	-	-	-
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	1,978,599.0	1,977,134.7	(1,464.3)
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	1,978,599.0	1,977,134.7	(1,464.3)

Дээрх хүснэгтээс үзэхэд дараах дансанд нөлөө бүхий өөрчлөлт гарсан байна. Үүнд:

- Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 86,634.1 мянган төгрөг болж 57,991.3 мянган төгрөгөөр өссөн нь “Ахмадын сан” буюу төрийн сан дахь 100130012503 дугаар дансны зарцуулаагүй үлдэгдлээс,
- Бараа материалын дансны үлдэгдэл 263,560.9 мянган төгрөг болж 74,895.5 мянган төгрөгөөр өссөн нь 249,613.1 мянган төгрөгийн бараа материал худалдан авсан, үнэ төлбөргүйгээр 53,611.8 мянган төгрөгийн бараа материал шилжүүлэн авсан, малын нас дэвшилт, төл малын орлогоос 1,927.8 мянган төгрөг, шатахууны урамшуулал 4,351.0 мянган төгрөгөөр, үндсэн хөрөнгийн данснаас шилжүүлэн авсан 4,370.5 мянган төгрөгөөр тус тус нэмэгдэж, 210,893.2 мянган төгрөгийн бараа материалыг зарцуулсан болон 21,388.9 мянган төгрөгийн бараа материал, зудын улмаас хорогдсон 5,644.8 мянган төгрөгийн 16 толгой үхрийг акталснаас,
- Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 1,609,337.7 мянган төгрөг болж 134,351.1 мянган төгрөгөөр буурсан нь 68,662.3 мянган төгрөгийн тоног төхөөрөмж худалдан авсан, 23,143.5 мянган төгрөгийн хөрөнгийг тооллогоор илрүүлж бүртгэсэн, ГХУС арга хэмжээний зардлаар 19,205.0 мянган төгрөгийн тоног төхөөрөмжийг үнэ төлбөргүй хүлээн авсан зэргээр нэмэгдэж, бараа материалын дансанд 4,370.5 мянган төгрөгийн тавилга хэрэгслийг шилжүүлсэн, 283,778.1 мянган төгрөгийн элэгдлийг нэмж байгуулснаас голлон шалтгаалсан байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Аймгийн Цагдаагийн газар нь 2023 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 3,110,084.0 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас дараах байдлаар нэмэгдүүлж баталсан байна. Үүнд:

- Цалин хөлс болон нэмэгдэл урамшлын зардлыг 799,182.9 мянган төгрөгөөр,
- Ажил олгогчоос төлөх НДШ-ийн зардлыг 9,635.7 мянган төгрөгөөр,
- Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний зардлыг 10,884.5 мянган төгрөгөөр,
- Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшууллын зардлыг 900.0 мянган төгрөгөөр тус тус нэмэгдүүлж,
- Байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 23,458.9 мянган төгрөгөөр,
- Хангамж, бараа материалын зардлыг 152,015.2 мянган төгрөгөөр,
- Нормативт зардлыг 16,826.8 мянган төгрөгөөр,
- Эд хогшил, урсгал засварын зардлыг 2,789.0 мянган төгрөгөөр,
- Томилот, зочны зардлыг 9,754.1 мянган төгрөгөөр,
- Бараа үйлчилгээний бусад зардлыг 1,000.0 мянган төгрөгөөр,
- Хөрөнгийн зардлыг 185,000.0 мянган төгрөгөөр тус тус бууруулж 3,539,843.1 мянган төгрөгөөр баталсан байна.

Тайлант оны батлагдсан төсвийг 793,197.4 мянган төгрөгөөр нэмэгдүүлсэн төсвийн тодотгол, зохицуулалт хийж /Цалин хөлс болон нэмэгдэл урамшлын зардлыг 321,292.5 мянган төгрөгөөр, ажил олгогчоос төлөх НДШ-ийн зардлыг 9,692.9 мянган төгрөгөөр, байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 1,500.0 мянган төгрөгөөр, хангамж, бараа материалын зардлыг 25,615.2 мянган төгрөгөөр, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардлыг 1,494.0 мянган төгрөгөөр, урсгал шилжүүлгийн зардлыг 436,064.8 мянган төгрөгөөр тус тус нэмэгдүүлж, эд хогшил худалдан авах зардлыг 1,200.0 мянган төгрөгөөр, томилот, зочны зардлыг 1,262.0 мянган төгрөгөөр бууруулсан байна./ **4,333,040.5** мянган төгрөгөөр баталсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 3 арга хэмжээг санхүүжүүлэхээр 4,323,035.5 мянган төгрөгийг улсын төсвөөс, 10,005.0 мянган төгрөгийг үйл ажиллагааны орлогоос төлөвлөж, гүйцэтгэлээр 4,323,035.5 мянган төгрөгийг улсын төсвөөс, 11,964.2 мянган төгрөгийг үйл ажиллагааны орлогоос санхүүжүүлэн урсгал үйл ажиллагаанд зарцуулж, өөрийн орлогын төлөвлөгөөнөөс давж биелсэн 1,959.2 мянган төгрөгийг оны эцэст төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл **4,326,529.6** мянган төгрөг буюу 99.8 хувьтай байгаа нь үндсэн үйл ажиллагааны зардлыг 459.2 мянган төгрөгөөр, байцаан шийтгэх ажиллагааны зардлыг 6,050.0 мянган төгрөгөөр хэмнэснээс голлон шалтгаалсан байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/					
Д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	Үндсэн үйл ажиллагааны зардал	3,884,015.7	3,883,556.5	(459.2)	99.9
2	Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал дэмжлэг	442,424.8	442,423.1	(1.7)	99.9
3	Байцаан шийтгэх ажиллагааны зардал	6,600.0	550.0	(6,050.0)	8.3
	Нийт	4,333,040.5	4,326,529.6	(6,510.9)	99.8

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд тус газар нь нэмэлт санхүүжилтийн дансанд нийт 129,519.8 мянган төгрөгийн орлого төвлөрүүлж, 108,311.8 мянган төгрөгийг зарцуулан, жилийн эцэст 21,207.9 мянган төгрөгийг төвлөрүүлсэн байна. Үүнд:

- Өмнөх оны эцэст төвлөрүүлсэн татаас санхүүжилтийн авлага 17,602.0 мянган төгрөг /2022 онд Ерөө сумын ЗДТГ-аас хүрээлэн буй орчны эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх хамгаалалтын постны зардалд олгосон 70,000.0 мянган төгрөгийн зарцуулагдаагүй үлдээгдэл/,
- ЦЕГ-аас орон нутгийн ИТХ-ын нөхөн болон дахин сонгуулийн хамгаалалтын зардалд 1,230.0 мянган төгрөг,
- Аймгийн ИТХ-ын даргын 2023 оны А/34 дүгээр захирамжийн дагуу гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын үр дүнг дээшлүүлэх зорилгоор Шуурхай удирдлагын тасагт шаардлагатай ухаалаг самбар, дагалдах тоног төхөөрөмж худалдан авах зардалд 18,886.5 мянган төгрөг,
- Аймгийн ИТХ-ын даргын 2023 оны А/53 дүгээр захирамжийн дагуу цагдаагийн байгууллагад бүртгэгдсэн өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн талаарх мэдээллийг шуурхай авах зорилгоор шаардлагатай таблет, дагалдах төхөөрөмж худалдан авах зардалд 18,599.7 мянган төгрөг,
- Аймгийн ИТХ-ын Ажлын албаны даргын А/46 дугаар тушаалын дагуу гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зорилгоор “Мал мах-2023” арга хэмжээг зохион байгуулах зардалд 2,000.0 мянган төгрөг,
- Аймгийн ИТХ-ын Ажлын албаны даргын А/53 дугаар тушаалын дагуу гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зорилгоор 2 байрлалд гэрэлтдэг явган хүний гарц байгуулах 17,100.0 мянган төгрөг,
- Аймгийн Засаг даргын МН-02 дугаар захирамжаар сэтгэцэд нөлөөлөх хорт ургамлын устгалын зардалд 25,000.0 мянган төгрөг,
- Аймгийн Засаг даргын А/243 дугаар захирамжийн дагуу ЗДНХ-өөс Ерөө сумын “Толгойтын даваа”-нд үүрэг гүйцэтгэж байгаа алба хаагчдын ээлж солих, эргүүл, хяналт шалгалт хийх албаны тээврийн хэрэгслийн засвар үйлчилгээ, шатахууны зардалд нийт 9,916.1 мянган төгрөг,

- Аймгийн Засаг даргын А/249 дүгээр захирамжийн дагуу аймгийн ЗДНХ-өөс Цагдаа дотоодын цэргийн байлдааны тугийг аялуулах ёслолын арга хэмжээний зардалд 2,495.5 мянган төгрөг,
- Аймгийн Засаг даргын А/347 дугаар захирамжийн дагуу аймгийн ОНХС-аас баяр наадмын хамгаалалтад ажиллах алба хаагчдын хоолны зардалд 8,110.0 мянган төгрөг,
- Аймгийн Засаг даргын А/635 дугаар захирамжийн дагуу ЗДНХ-өөс гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг хүрээнд Шуурхай удирдлагын тасагт шаардлагатай суурин компьютер худалдан авахад 8,199.8 төгрөг,
- Сүхбаатар сумын ОНХС-аас сумын наадмын хамгаалалтын зардалд 1,000.0 сая төгрөг.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Тус газар нь тайлант онд шатахуун, шатах тослох материалын худалдан авах ажиллагааны урилгыг ТБОНӨХБАҮХА тухай хуульд заасны дагуу tender.gov.mn-д цахим сайтад байршуулж, зохион байгуулсан байна. Үүнийг дараах хүснэгтээр харуулбал:

/ мянган төгрөгөөр /

№	Тухайн жилд худалдан авах бараа, ажил, үйлчилгээний нэр төрөл, тоо, хэмжээ, хүчин чадал	Батлагдсан төсөв	Гэрээний дүн	Худалдан авах ажиллагаанд мөрдөх журам /Тендер шалгаруулалтын арга/
1	Шатахуун, шатах тослох материал	168,319.2	167,456.0	НТШ
	Нийт дүн	168,319.2	167,456.0	

Бэлтгэн нийлүүлэгчийг сонгон шалгаруулах нээлттэй тендер шалгаруулалтад “Шунхлай петролиум”, “Ник” ХХК-иуд оролцож, гүйцэтгэгчээр шалгарсан Ник ХХК-тай 2023 оны 04 дүгээр сарын 24-ний өдөр гэрээ байгуулан, худалдан авалтыг гүйцэтгэсэн байна.

Тайлант онд Алтан Есүй, Сэлэнгэ титан ХХК-иудтай барилгын засварын материал, Цахим ертөнц ХХК-тай хүнс, бичиг хэрэг, цэвэрлэгээний материал, иргэн Д.Цэцэгмаатай мах, дайвар бүтээгдэхүүн авах гэрээг тус тус байгуулан, худалдан авалтыг гүйцэтгэсэн байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Сэлэнгэ аймгийн Цагдаагийн газрын 2023 оны 12 дугаар

сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Мөн төсвийн төлөвлөлт, болон анхан шатны баримтын бүрдүүлэлттэй холбоотой зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор С.Баасансүрэн гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Б.Батмөнх, дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

Сэлэнгэ аймгийн Цагдаагийн газрын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт 2024 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 46/1-351 дүгээр албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2022 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 3,056,002.3 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 30,560.0 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагатай гэж үзсэн.

Тайлант онд тус газрын батлагдсан төсөвт материаллаг хэмжээний өөрчлөлт гарсан тул гүйцэтгэлийн үеийн материаллаг байдлыг 2023 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал болох 4,553,685.2 мянган төгрөгөөс 1.0 хувиар тооцон 45,536.8 мянган төгрөгөөр шинэчлэн тогтоолоо.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

ЦЕГ-ын Тэргүүн дэд даргын 2023 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн 2/352 дугаар албан бичгийн 9, Санхүү, ар талын албаны 2023 оны 12 дугаар сарын 21-ний өдрийн 16/2918 дугаар албан бичгийн 4 дүгээрт *"Төсвийн зардлын үлдэгдлээр нь байгууллагынхаа хэрэгцээнд шаардлагатай материалыг худалдан авах болон "Ахмадын сан"-д шилжүүлж, төсвийг бүрэн зарцуулах ажлыг зохион байгуулах"* гэж үүрэг, чиглэлийг өгсний дагуу хангамж, бараа материалын зардлын хэмнэлт болох 51,208.6 мянган төгрөгөөр хэрэгцээнээс илүү шатахуун худалдан авч нөөцөлсөн байна. Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.6 дахь *"Нөөцлөх шаардлагатай бараа, материалыг үр ашиггүй удаан хадгалах, шаардлагагүйгээр их хэмжээгээр бараа, материал бэлтгэх, нөөцлөх"* гэсэн заалтыг зөрчсөн байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны цахим хуудаст мэдээлбэл зохих 28 төрлийн 154 мэдээллээс 150 мэдээллийг хугацаанд нь мэдээлж, дараах 4 мэдээллийг 8 дугаар сард хугацаа хоцроож мэдээлсэн байна. Үүнд:

- Төсвийн байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт, хэмнэлтийн шалтгаан, тайлбарын хамт-дийн засгийн ангилал /,
- Төсвийн байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэл-хөтөлбөр, зориулалт,
- Байгууллагын батлагдсан орон тоонд орсон өөрчлөлт,
- Дараа жилийн төсвийн төсөл.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны мэдээллийг хугацаанд нь мэдээлж байх зөвлөмж өгөв.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудиторын 2023 оны 10 дугаар сарын 26-ны 123 дугаар “Санхүүгийн тайланд аудит хийх тухай” албан бичгийг хүргүүлсэн бөгөөд тус байгууллагын 2023 оны 3 дугаар улирлын санхүүгийн тайланд хийсэн завсрын үеийн санхүүгийн тайлангийн аудитаар алдаа, зөрчил илрээгүй байна.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар нийт 22,229.3 мянган төгрөгийн 2 зөрчилд зөвлөмж өгснийг нотлох баримттай тулган шалгахад бүрэн биелсэн байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

		/мянган төгрөгөөр/
Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт	Биелэлт

	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Зөвлөмж	1	18,082.0	1	18,082.0	100.0
	1	4,147.3	1	4,147.3	100.0
Нийт дүн	2	22,229.3	1	22,229.3	100.0

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Сэлэнгэ аймгийн Цагдаагийн төсвийн шууд захирагчийн бус дээд шатны төсвийн захирагчийн шийдвэрээр хэрэгжсэн дараах асуудлыг дээд шатны төсвийн захирагчийн санхүүгийн тайланд хийх аудитын анхааралд хандуулж байна. Үүнд:

ЦЕГ-ын даргын 2023 оны 2/352, Санхүү, ар талын албаны даргын 2023 оны 16/2918 дугаар албан бичгүүдээр “Төсвийн зардлын үлдэгдлээр байгууллагынхаа хэрэгцээнд шаардлагатай материалыг худалдан авах болон “Ахмадын сан”-д шилжүүлж, төсвийг бүрэн зарцуулах ажлыг зохион байгуулах” гэж үүрэг, чиглэл өгсний дагуу дараах гүйлгээг хийж гүйцэтгэсэн байна.

- Тээвэр, шатахууны зардлын хэмнэлт **51,208.6** мянган төгрөгөөр хэрэгцээнээс илүү шатахуун худалдан авч, нөөцөлсөн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 7 дугаар зүйлийн 7.7 дахь “... төсвийн жил дуусахад төсвийн захирагчийн төсөв зарцуулах эрх нь дуусгавар болох бөгөөд ... төсвийн зарцуулагдаагүй үлдэгдлийг тухайн шатны төсвийн ерөнхий дансанд татан төвлөрүүлнэ”, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.6 дахь “нөөцлөх шаардлагатай бараа, материалыг үр ашиггүй удаан хадгалах, шаардлагагүйгээр их хэмжээгээр бараа, материал бэлтгэх, нөөцлөх” гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

- Цалингийн хэмнэлт 38,500.0 мянган төгрөг, бусад зардлын хэмнэлт 34,721.9 мянган төгрөг зэрэг нийт **73,221.9** мянган төгрөгийг “Ахмадын сан”-ийн дансанд шилжүүлсэн байна.

Энэ нь Засгийн газрын 2017 оны 197 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар баталсан “Ахмадын сан байгуулан ажиллуулах журам”-ын 1.3 дахь “Төсөвт байгууллагын тухайд цалингийн сангийн 3 хүртэлх хувьтай тэнцэх хэмжээний мөнгөн хөрөнгөөр сан байгуулж, шаардагдах хөрөнгийг төсөвтөө жил бүр тусгана” гэсэн заалттай нийцэхгүй байна.

Иймд ахмадын санд төвлөрүүлэх хөрөнгийг тухайн жилийн төсөвт тусгуулж батлуулсны үндсэн дээр санхүүжүүлэх нь зүйтэй байна.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 18,100.0 мянган төгрөгийн 2 зөрчил¹ илэрч зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэв.

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

5.1 Албан шаардлага

1. Газрын даргын 2023 оны 11 дүгээр сарын 27-ны өдрийн Б/171 дүгээр тушаалаар Хилийн цэргийн 0101 дүгээр ангийн 90 жилийн ойг тохиолдуулан тус ангийн 10 алба хаагчид нийт 1,000.0 мянган төгрөгийн мөнгөн шагналыг нэг удаагийн тэтгэмж, урамшууллын зардлаас олгосон байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь “Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулж байх албан шаардлага хүргүүлэв.

2. Аймгийн ИТХ-ын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардлаас тус газрын нэмэлт санхүүжилтийн дансанд “Сүхбаатар сумын төв зам дагуух 2 байрлалд гэрэлтдэг явган хүний гарц байгуулах ажил”-ыг гүйцэтгүүлэхээр санхүүжүүлсэн 17,100.0 мянган төгрөгийн төсөл, арга хэмжээ хэрэгжээгүй атал санхүүжилтийг төсөвт татан төвлөрүүлэлгүйгээр Алтан нутуг гэрэгэ ХХК-д шилжүүлсэн боловч урьдчилж гарсан зардлаар бүртгэж, тайлагнаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4 дэх “Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ:”, 14.4.2 дахь “... **авлага**”, Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалын хавсралтаар баталсан “Нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын 4.28 дахь “Бэлтгэн нийлүүлэгч болон хувь хүмүүст төлсөн урьдчилгаа, ба урьдчилан гарсан зардлыг: Дт.Урьдчилж төлсөн төлбөрүүд, Кт.Мөнгөн хөрөнгө” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Нэмэлт санхүүжилтийн дансны зарцуулагдаагүй үлдэгдлийг төсөвт татан төвлөрүүлж, авлагаар бүртгэж, тайлагнаж байх албан шаардлага хүргүүлэх.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн	
							Тоо	Дүн	Тоо	Дүн			

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллага д шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн

Урьдчилж гарсан зардлыг бүртгэж, тайлагнаагүй	1	17,100.0			1	17,100.0				
Батлагдсан төсвийг зориулалт бусаар зарцуулсан.	1	1,000.0			1	1,000.0				
Дүн	2	18,100.0	-	-	2	18,100.0				

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
	Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
			Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна.	4	-					4	-
Дүн	4						4	
Бусад хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Дүн	-	-	-	-	-	-	-	-
Нийт дүн	4						4	-